

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТГИЙН ХУРЛЫН НӨХӨН БОЛОН ДАХИН
СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗАРДЛЫН
ТӨЛӨВЛӨЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ГҮЙЦЭТГЭЛ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/20-13-НА-СТА

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Ж.Бямбацогт

Утас: 70272287 Цахим хаяг: byambatsogtj@audit.gov.mn

Аудитор Б.Нямсүрэн

Утас: 70273204 Цахим хаяг: nyamsurenb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар.....	2
Хүснэгтийн жагсаалт	2
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт	3
Аудит хийх үндэслэл:.....	3
Аудитын зорилт:.....	3
Аудитын хамрах хүрээ:	3
Аудит хийх хугацаа, бүрэлдэхүүн:.....	3
Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл:.....	3
Аудитын арга зүй:	3
Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:	4
Үндсэн мэдээлэл.....	4
Бүлэг 1. СЕХ-ны ажлын алба нь улсын төсвөөс олгох сонгуулийн зардлын төсөв болон зарцуулалтын тухай тайлбарыг албан тоотоор ирүүлж арга зүйгээр ханган ажиллажээ.	6
Орон нутгийн нөхөн болон дахин сонгуулийг зохион байгуулахтай холбогдон УБЕГ-аас 4,698.0 мянган төгрөг хуваарилсан байна.	6
СЕХ-оос ирүүлсэн санхүүжилтийг 2 сумын сонгуулийн хороонд 20,130.0 мянган төгрөгийг, аймгийн сонгуулийн хороонд 16,707.0 мянган төгрөгийг зарцуулахаар хуваарилсан байна.	7
Бүлэг 2. СЕХ-ний баталсан журмын дагуу аймаг, сумын Сонгуулийн хорооны зардлын төсөв, гүйцэтгэлийг тайлагнасан байна.	8
Аймгийн сонгуулийн хороо 1,864.0 мянган төгрөгийг арвилан хэмнэлттэй зарцуулж, СЕХ-ний дансанд буцаан төвлөрүүлсэн байна	8
Хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.	10
ДҮГНЭЛТ.....	11
ЗӨВЛӨМЖ	12
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ	13

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АНСДИТХСТХ	Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
УИХ	Улсын Их Хурал

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Төв аймгийн сумдын ИТХ-ын нөхөн болон дахин сонгуульд нэр дэвшигчдэд өгсөн санал	5
Хүснэгт 2. Нөхөн болон дахин сонгуулийн зардлын төсөв	6
Хүснэгт 3. УБЕГ-ын даргын тушаалаар батлагдсан төсөв зардлын зүйл	7
Хүснэгт 4. Сонгуулийн зардлын батлагдсан төсвийн хуваарь	8
Хүснэгт 5. Аймгийн сонгуулийн хорооны зардлын гүйцэтгэл	9
Хүснэгт 6. УБЕГ-аас санхүүжүүлсэн зардлын төсөв гүйцэтгэл	10

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудит хийх үндэслэл:

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3-т заасан бүрэн эрхийн хүрээнд Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.8, МУ-ын Ерөнхий аудиторын 2022.04.13-ны өдрийн А/34 дүгээр тушаалыг үндэслэн “Орон нутгийн Хурлын нөхөн болон дахин сонгууль зохион байгуулах зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэл” сэдэвт аудитыг хийж гүйцэтгэлээ.

Аудитын зорилт:

Сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулахад аудитын зорилт чиглэгдэв.

Энэ зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

- Сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нөхөн болон дахин сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журам, зориулалтын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх
- Сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн болон дахин сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх

Аудитын хамрах хүрээ:

Аудитад аймгийн сонгуулийн хороо, сумын сонгуулийн хороо, хэсэг, Улсын бүртгэлийн хэлтэс зэрэг байгууллагууд хамрагдсан.

Аудит хийх хугацаа, бүрэлдэхүүн:

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал удирдан, аудитор Ж.Бямбацогт, Б.Нямсүрэн нар 2022 оны 07 дугаар сарын 08-аас 07 дугаар сарын 18-ыг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэв.

Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл:

Аудитын тайлан ерөнхий зүйл, аудитын дүн, аудитын дүгнэлт, зөвлөмж, холбогдох газрын санал гэсэн агуулгаар бичигдлээ.

Аудитад аймаг, сумдын сонгуулийн хороодын болон Улсын бүртгэлийн хэлтэст улсын төсвөөс олгосон санхүүжилтийн зардлын зарцуулалт, санхүүгийн баримтуудыг хамруулав.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 3000-3100, Монгол улсын Төрийн аудитын стандарт, Гүйцэтгэлийн аудит MNS 6817-7:2020, Гүйцэтгэлийн болон Санхүүгийн аудитын арга зүйг ашиглан улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтын талаар холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан судалгаа, баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийн аудитын судалгаа, хөтөлбөр, арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитын зорилттой холбоотой дараах хууль, дүрэм, журам, зааврын холбогдох заалтуудыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль
- АНСДИТХСТХ
- Сонгуулийн төв байгууллагын тухай хууль
- Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль
- Дээрх хуулиудтай нийцүүлэн гаргасан тогтоол, журам

Үндсэн мэдээлэл

Төв аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2022 оны 03 сарын 28-ны өдрийн ээлжит бус 2 дугаар хуралдааны 03 дугаар тогтоолоор Алтанбулаг, Баянжаргалан сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн болон дахин сонгуулийг зохион байгуулж явуулах Сонгуулийн хороог аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга Ч.Жавзанпагмаар ахлуулан 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан байна.

Төв аймгийн Сонгуулийн хорооны 2022 оны 04 сарын 12-ны 01 дүгээр захирамжаар Сонгуулийн хорооны төсвийг хариуцан ажиллах нягтлан бодогчийг аймгийн ЗДТГ-ын нягтлан бодогч Э.Бүжинлхамыг томилсон байна. Баянжаргалан, Алтанбулаг сумд Сонгуулийн хорооны дарга, нягтлан бодогчийг сумын ИТХ-ын тогтоолоор томилон ажиллуулсан байна.

АНСДИТХСТХ-ийн 10 дугаар зүйлийн 10.6-д “Орон нутгийн Хурлын ээлжит бус, нөхөн болон дахин сонгууль зохион байгуулахтай холбогдон гарах энэ хуулийн 10.1, 10.2, 10.3, 10.4-т заасан байгууллагуудын зардлыг Монгол Улсын Их Хурал баталж улсын төсвөөс санхүүжүүлнэ” гэж заасны дагуу СЕХ-ны ажлын албаны даргын 2022.06.15-ны өдрийн А/06 дугаар тушаалаар 36,837.0 мянган төгрөг батлан санхүүжүүлсэн байна.

АНСДИТХСТХ-ийн 13 дугаар зүйлд заасны дагуу Төв аймгийн сонгуулийн хороо, 2 сумын сонгуулийн хороо, 3 хэсгийн хороонд нийт 42 төрийн албан хаагч төлөвлөгөөний дагуу оролцон ажиллажээ.

Орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны нөхөн болон дахин сонгуульд 2 сумын 3 мандатад 6 нэр дэвшигч өрсөлдсөн байна.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 3 мандатын төлөө 6 нэр дэвшигч дэвшсэнээс 5 эрэгтэй, 1 эмэгтэй нэр дэвшигч байна. Намын харьяаллаар авч үзвэл МАН-аас 3 нэр дэвшигч, АН-аас 3 нэр дэвшигч оролцсон байна.

Сонгогчдын санал авах ажиллагааг АНСДИТХСТХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.9-д заасны дагуу СЕХ-ны 2022 оны 02 сарын 10-ны өдрийн №05 дугаарын “Цаг хугацааны хуваарь батлах тухай” тогтоолоор 2022 оны 06 сарын 19-ний өдрийн 07:00-20:00 цагийн хооронд зохион байгуулахаар баталж, зохион байгуулсан байна. Сонгуулийн тойргийн хэмжээнд сонгогчдын нэрсийн жагсаалтад санал өгөх сонгогч 1156 хүн улсын бүртгэлд бүртгэгдсэнээс 425 буюу 36,7 хувь нь санал хураалтад оролцжээ. Орон нутгийн сонгуулийн санал хураалтын үр дүнгээр Баянжаргалан сумын 2-р тойрогт нэр дэвшигчдэд өгсөн сонгогчийн санал тэнцсэн тул нэмэлт санал хураалтыг 2022 оны 06 сарын 25-ны өдрийн бямба гаригт 07:00-20:00 цагийн хооронд зохион явуулсан байна. Нэмэлт санал хураалтад улсын төсвөөс нэмэлт санхүүжилт олгоогүй байна.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг сонгох сонгуулийн үр дүнг авч үзэхэд

Алтанбулаг сум 1 мандатаас МАН 1, Баянжаргалан сум 2 мандатаас МАН 1, АН 1 суудал авсан байна.

Хүснэгт 1. Төв аймгийн сумдын ИТХ-ын нөхөн болон дахин сонгуульд нэр дэвшигчдэд өгсөн санал

№	Нам, эвсэл, бие даагчийн нэр	Нэр дэвшигчийн тоо	Авсан саналын	
			тоо	хувь
1	МАН	3	271	64.1
2	АН	3	152	35.9
3	Хүчингүй саналын хуудас		2	
нийт		6	425	100.0

Эх сурвалж: <https://gec.gov.mn/>

Аймгийн Улсын Бүртгэлийн хэлтсийн албан хаагчид нь орон нутгийн сонгуулийн үйл ажиллагаанд АНСДИТХСТХ-ийн 4 дүгээр бүлэгт заасан чиг үүргийн дагуу шилжилт хөдөлгөөн болон санал авах сонгогчийн бүртгэлийн программ хангамжийг ажиллуулж, сонгогчийн хувийн мэдээллийг нягтлан шалгах, ирцийн мэдээ хэвлэх, бүртгэлийн хуудас хэвлэх, сонгогчийн нэрсийн жагсаалтад тусгах өөрчлөлтийг ирц бүртгэлийн программд оруулах, сонгогчдын нэрийн жагсаалт хэвлэх, ирцийн бүртгэлийн программ түгжих, тоног төхөөрөмж хүлээлцэх, түүнтэй холбоотой сургалт зохион байгуулах зэрэг үүргийг хэрэгжүүлсэн байна.

АНСДИТХСТХ-ийн 10 дугаар зүйлийн 10.6-д “Орон нутгийн Хурлын ээлжит бус, нөхөн болон дахин сонгууль зохион байгуулахтай холбогдон гарах энэ хуулийн 10.1, 10.2, 10.3, 10.4-т заасан байгууллагуудын зардлыг Монгол Улсын Их Хурал баталж улсын төсвөөс санхүүжүүлнэ” гэж заасны дагуу УБЕГ-ын даргын 2022 оны 05 сарын 11-ний А/368 дугаар тушаалаар сонгууль зохион байгуулах зардлаас 4,698.0 мянган төгрөг, СЕХ-ны ажлын албаны даргын 2022.06.15-ны өдрийн А/06 дугаар захирамжаар 36,837.0 мянган төгрөгийг санхүүжүүлэн, зарцуулсан байна.

Бүлэг 1. СЕХ-ны ажлын алба нь улсын төсвөөс олгох сонгуулийн зардлын төсөв болон зарцуулалтын тухай тайлбарыг албан тоотоор ирүүлж арга зүйгээр ханган ажиллажээ.

Орон нутгийн нөхөн болон дахин сонгуулийг зохион байгуулахтай холбогдон УБЕГ-аас 4,698.0 мянган төгрөг хуваарилсан байна.

АНСДИТХСТХ-ийн 10 дугаар зүйлийн 10.6-д “Орон нутгийн Хурлын ээлжит бус, нөхөн болон дахин сонгууль зохион байгуулахтай холбогдон гарах энэ хуулийн 10.1, 10.2, 10.3, 10.4-т заасан байгууллагуудын зардлыг Монгол Улсын Их Хурал баталж улсын төсвөөс санхүүжүүлнэ” гэж заасны дагуу СЕХ-ний 2022 оны төсвөөс СЕХ-ний даргын захирамжаар аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны зардлыг хуваарилан зарцуулсан байна.

Сонгуулийн Ерөнхий Хорооны ажлын албаны даргын 2022.06.06-ны өдрийн А/17 тоот “Аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны сонгуулийн зардлын хуваарь батлах тухай” тушаалаар аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны ээлжит бус, нөхөн болон дахин сонгуулийг харьяалах нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах, аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны зардлын хуваарийг хавсралтаар баталж, батлагдсан төсвийг тухай бүр баталж, хяналт тавьж ажиллахыг сонгуулийн хорооны дарга нарт даалгасан байна.

СЕХ-ны ажлын албаны даргын тушаалаар Төв аймагт орон нутгийн сонгууль зохион байгуулах зардалд 36,837.0 мянган төгрөг хуваарилсан байна.

Хүснэгт 2. Нөхөн болон дахин сонгуулийн зардлын төсөв

		/төгрөгөөр/
Зардлын нэр	Төсөв	
Маягт хэвлүүлэх зардал	150,000	
Үнэмлэх хэвлэх зардал	100,000	
Сонгуулийн хорооны гишүүдийн сургалт	450,000	
МТБ-н гишүүн, даамлын сургалт	50,000	
Бичиг хэрэг	900,000	
Шуудан холбоо	1,050,000	
Унааны зардал	3,080,000	
Санал авах байр бэлтгэх	900,000	
Саналын хуудас, ICP төхөөрөмж авах, хүлээлгэн өгөх унаа, томилолтын зардал	4,530,000	
МТБ-н мэдээ дамжуулах холбоо, унааны зардал	130,000	
САС ашиглахтай холбоотой гарах зардал /Эрчим хүчний эх үүсвэр бэлтгэх/	240,000	
Мэдээ дамжуулах унааны зардал	210,000	
Сурталчилгааны зардал	2,000,000	
Томилолт	1,807,000	
Сонгуулийн хорооны гишүүний урамшуулал, хоолны зардал	16,920,000	
Мэдээллийн технологийн багийн гишүүн даамлын урамшуулал, хоолны зардал	2,820,000	
Болзошгүй зардал	1,500,000	
Төвлөрүүлсэн үлдэгдэл		
Дүн	36,837,000	

Эх сурвалж: СЕХ-ны ажлын албаны даргын 2022 оны 3/97 дугаар албан бичгийн хавсралт

СЕХ нь орон нутгийн ээлжит бус сонгуулийг зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс олгох зардлын талаар орон нутгийн байгууллагаас урьдчилан тооцсон судалгаа, зардлын төсвийн төслийн санал авдаггүй байна.

Аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн зохион байгуулахад зарцуулах зардалд УБЕГ-аас 4,698.0 мянган төгрөг хуваарилан ирүүлсэн байна.

УБЕГ-ын даргын 2022.05.11-ний өдрийн А/368 дугаар тушаалаар аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль зохион байгуулах зардлын төсвийг баталсан байна.

Хүснэгт 3. УБЕГ-ын даргын тушаалаар батлагдсан төсөв зардлын зүйл

		/төгрөгөөр/
Зардлын нэр		Төсөв
Сонгогчийн нэрсийн жагсаалт болон тоног төхөөрөмж авч ирэх хүргэх шатахуун, томилолт		988,000
Сонгуулийн бичиг хэрэг		258,500
Томилолт		976,500
Сургалтын зардал		112,500
Сонгуулийн урамшуулал		2,362,500
Дүн		4,698,000

Эх сурвалж: УБЕГ-ын даргын 2022 оны А/368 дугаар тушаал

УБЕГ-ын 2022 оны төсвийн аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын ээлжит бус, нөхөн дахин сонгууль зохион байгуулах зардлаас 4,698.0 мянган төгрөг санхүүжүүлснээс, гүйцэтгэлээр 4,698.0 мянган төгрөг зарцуулсан байна.

СЕХ-оос ирүүлсэн санхүүжилтийг 2 сумын сонгуулийн хороонд 20,130.0 мянган төгрөгийг, аймгийн сонгуулийн хороонд 16,707.0 мянган төгрөгийг зарцуулахаар хуваарилсан байна.

Сонгуулийн Ерөнхий Хорооны ажлын алба нь улсын төсвөөс олгох сонгуулийн хорооны зардлын төсөв болон санхүүжилтийн зарцуулалтын тухай тайлбар, аргачлалыг тухай бүрд албан бичгээр ирүүлж, санхүүжилтийг аймгийн Сонгуулийн хорооны харилцах дансанд шилжүүлсэн байна. Үүнд: Сонгуулийн Ерөнхий Хорооны ажлын албаны

- 2022.04.21-ний өдрийн 3/51 дугаар албан бичгийн 1 дүгээр хавсралтаар аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны төсвийн хуваарийн тухай тайлбар, 2 дугаар хавсралтаар Төв аймгийн сонгуулийн хорооны төсвийн хуваарь 6,680.0 мянган төгрөгийг,
- 2022.06.07-ны өдрийн 3/82 дугаар албан бичгийн хавсралтаар төсвийн 2 дахь хэсгийн санхүүжилтийн зарцуулалтын тухай тайлбар болон зардлын зүйлээр хуваарилан 34,485.0 мянган төгрөгийн 27805.0 мянган төгрөгийг,
- 2022.06.20-ны өдрийн 3/97 дугаар албан бичгийн хавсралтаар нөхөн болон дахин сонгуулийн Төв аймгийн сонгуулийн хорооны төсвийн хуваарийг шинэчлэн 36,837.0 мянган төгрөгөөр баталж, үлдэгдэл 2,352.0 мянган төгрөгийг 2022.06.10-ны өдөр тус тус шилжүүлсэн байна.

СЕХ-ны ажлын албанаас ирүүлсэн 34,485.0 мянган төгрөгийн төсвийн хуваарийг саналын хуудас, ИСР төхөөрөмж авах, хүлээлгэн өгөх унаа, томилолтын зардлыг 1,642.0 мянган төгрөгөөр, томилолтын зардлыг 710.0 мянган төгрөгөөр

нэмэгдүүлж нийт 36,837.0 мянган төгрөгөөр дахин шинэчилж ирүүлсэн байна.

Төв аймгийн Сонгуулийн хороо нь нийт 36,837.0 мянган төгрөгийн санхүүжилт ирснээс СЕХ-оос ирүүлсэн тайлбарыг үндэслэн 2 сумын сонгуулийн хороодод 20,130.0 мянган төгрөгийг, аймгийн сонгуулийн хороонд 16,707.0 мянган төгрөгийг зарцуулахаар хуваарилан санхүүжилтийг олгожээ. Сонгуулийн зардлын батлагдсан төсвийг хүснэгтээр харуулав.

Хүснэгт 4. Сонгуулийн зардлын батлагдсан төсвийн хуваарь

		/төгрөгөөр/
Сонгуулийн хорооны нэр		Төсөв
Алтанбулаг		7,740,000
Баянжаргалан		12,390,000
Төв аймгийн Сонгуулийн хороо		16,707,000
Дүн		36,837,000

Эх сурвалж: Сонгуулийн хорооны мэдээ

Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль зохион байгуулахтай холбогдон гарах зардалд шаардагдах хөрөнгийг УБЕГ-ын 2022 оны төсвийн аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгууль зохион байгуулах зардлаас санхүүжүүлсэн байна.

УБЕГ-ын даргын 2022.05.11-ны өдрийн А/368 тоот тушаалын хавсралтаар Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын ээлжит бус, нөхөн болон дахин сонгууль зохион байгуулах зардлын төсвийг баталж, зардлын зарцуулалтын тайлбарын хамт ирүүлжээ.

Аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн нэмэлт санхүүжилтийн дансанд 1 удаагийн шилжүүлгээр 4,698.0 мянган төгрөгийн санхүүжилт ирсэн байна.

Бүлэг 2. СЕХ-ний баталсан журмын дагуу аймаг, сумын Сонгуулийн хорооны зардлын төсөв, гүйцэтгэлийг тайлагнасан байна.

Аймгийн сонгуулийн хороо 1,864.0 мянган төгрөгийг арвилан хэмнэлттэй зарцуулж, СЕХ-ний дансанд буцаан төвлөрүүлсэн байна

Сонгуулийн ерөнхий хорооноос 3-н удаагийн шилжүүлгээр нийт 36,837.0 мянган төгрөгийг батлагдсан төсвийн хуваарийн дагуу аймгийн Сонгуулийн хорооны харилцах дансанд төвлөрүүлсэн байна.

Төв аймгийн сонгуулийн хороо нь СЕХ-ний ирүүлсэн төсвийн зарцуулалтын тайлбарын дагуу санхүүжилтийг аймаг, сумдын Сонгуулийн хороодод хуваарилан шилжүүлж, тухай бүрд арга зүйн зөвлөмж өгч ажилласан байна.

Сумдын сонгууль зохион байгуулахаар ирүүлсэн батлагдсан төсвийг зориулалтын дагуу арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэхийг аудитын явцад анхан шатны баримт материалаас түүвэрлэн шалгалаа. Аймгийн сонгуулийн хороо нь төсвийг хэмнэлттэй зарцуулснаар 1,864.0 мянган төгрөгийг хэмнэж, зарцуулаагүй үлдэгдлийг Сонгуулийн ерөнхий хорооны Төрийн сангийн 100900022001 дугаарын дансанд буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсвийн зарцуулалттай холбоотой дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Баянжаргалан сум сонгуулийн хэсгийн хороод хувь хүнээс цахилгаан эх

үүсвэрийн мотор 115.0 мянган төгрөгөөр түрээслэхдээ ХХОАТ суутгаагүй, зарцуулагдаагүй шатахууныг орлогод аваагүй байна.

Төв аймгийн сонгуулийн хорооны зардлын нэгдсэн тайлангаар нийт 36,837.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас, гүйцэтгэлээр 34,973.0 мянган төгрөг зарцуулж, 1,864.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэйгээр зардлыг эдийн засгийн ангиллаар тайлагнасан байна.

Хүснэгт 5. Аймгийн сонгуулийн хорооны зардлын гүйцэтгэл

/мянган төгрөг/

Зардлын нэр	Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл
Маягт хэвлүүлэх зардал	150,000	150,000.0	-
Үнэмлэх хэвлэх зардал	100,000	100,000.0	-
Сонгуулийн хорооны гишүүдийн сургалт	450,000	450,000.0	-
МТБ-н гишүүн, даамлын сургалт	50,000	50,000.0	-
Бичиг хэрэг	900,000	900,000.0	-
Шуудан холбоо	1,050,000	1,050,000.0	-
Унааны зардал	3,080,000	3,080,000.0	-
Санал авах байр бэлтгэх	900,000	900,000.0	-
Саналын хуудас, ИСР төхөөрөмж авах, хүлээлгэн өгөх унаа, томилолтын зардал	4,530,000	4,436,000.0	94,000.0
МТБ-н мэдээ дамжуулах холбоо, унааны зардал	130,000	60,000.0	70,000.0
САС ашиглахтай холбоотой гарах зардал /Эрчим хүчний эх үүсвэр бэлтгэх/	240,000	180,000.0	60,000.0
Мэдээ дамжуулах унааны зардал	210,000	70,000.0	140,000.0
Сурталчилгааны зардал	2,000,000	2,000,000.0	-
Томилолт	1,807,000	1,807,000.0	-
Сонгуулийн хорооны гишүүний урамшуулал, хоолны зардал	16,920,000	16,920,000.0	-
Мэдээллийн технологийн багийн гишүүн даамлын урамшуулал, хоолны зардал	2,820,000	2,820,000.0	-
Болзошгүй зардал	1,500,000		1,500,000.0
Төвлөрүүлсэн үлдэгдэл		-	1,864,000.0
Дүн	36,837,000	34,973,000	

Эх сурвалж: Сонгуулийн хорооны мэдээ

Аймаг, сумдын Сонгуулийн хорооны зардлын нэгдсэн тайлангаар хэмнэгдсэн зардлыг авч үзвэл саналын хуудас, ИСР төхөөрөмж авах, хүлээлгэн өгөх унаа, томилолтын зардал 94.0 мянган төгрөг, МТБ-н мэдээ дамжуулах холбоо, унааны зардал 70.0 мянган төгрөг, Эрчим хүчний эх үүсвэр бэлтгэх зардал 60.0 мянган төгрөг, мэдээ дамжуулах унааны зардал 140.0 мянган төгрөг, болзошгүй зардал 1,500.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

Орон нутгийн Сонгуулийн зардлын гүйцэтгэл, тайлагналттай холбоотой дараах зөрчил дутагдал илэрлээ. Үүнд:

- Баянжаргалан, Алтанбулаг сумдын Сонгуулийн хороо нь шуудан холбооны зардалд минут цагаар ярьсан талаар тайлан гаргуулж аваагүй, нэгж худалдан авсан татварын цахим баримт нь байгууллагын нэр дээр бүртгэгдээгүй байна.

УБЕГ-аас ирүүлсэн санхүүжилтийг аймгийн УБХ-ийн нэмэлт санхүүжилтийн харилцах дансанд төвлөрүүлж, бараа үйлчилгээний бусад зардлаар тайлагнасан байна.

Хүснэгт 6. УБЕГ-аас санхүүжүүлсэн зардлын төсөв гүйцэтгэл

Зардлын нэр	Төсөв	Гүйцэтгэл	/төгрөгөөр/ Үлдэгдэл
			Үлдэгдэл
Сонгогчийн нэрсийн жагсаалт болон тоног төхөөрөмж авч ирэх хүргэх шатахуун, томилолт	988,000	988,000.0	-
Сонгуулийн бичиг хэрэг	258,500	258,500.0	-
Томилолт	976,500	976,500.0	-
Сургалтын зардал	112,500	112,500.0	-
Сонгуулийн урамшуулал	2,362,500	2,362,500.0	-
Дүн	4,698,000	4,698,000	-

Эх сурвалж: УБХ-ийн мэдээ тайлан

Хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.

Сонгуулийн ерөнхий хорооны 2016 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн 04 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай" журмын 3.4-д заасны дагуу Төв аймгийн сонгуулийн хороо нь сумын сонгуулийн хорооны, төв комисс нь салбар комиссын сонгуулийн зардлын зарцуулалтад тус тус хяналт тавина гэсэн заалтыг мөрдлөг болгон ажилласан байна.

Аймгийн Сонгуулийн хороо нь сумдын төсвийн хуваарилалтыг Сонгуулийн хорооны бүх гишүүдийн хурлаараа хэлэлцэн шийдвэрлүүлж, урамшуулалтай холбоотой зардлуудыг хэлэлцэн захирамж гарган зарцуулсан байна. Хөрөнгийн зарцуулалтад өдөр тутмын хяналтыг нягтлан бодогч нар хэрэгжүүлэн ажилласан байна.

Аймгийн Сонгуулийн хорооны даргын баталсан хяналт, шалгалт хийх удирдамжийн дагуу аймгийн Сонгуулийн хорооны нарийн бичгээр ахлуулсан ажлын хэсэг сумдад ажиллаж, сумын Сонгуулийн үйл ажиллагааг эрчимжүүлж, гишүүдийг чадавхжуулах, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулсан байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

1. СЕХ-ны ажлын алба нь улсын төсвөөс олгох 36,837.0 мянган төгрөгийн сонгуулийн зардлын төсөв болон зарцуулалтын тухай тайлбарыг албан тоотоор ирүүлж, арга зүйгээр ханган ажиллажээ.
2. Аймгийн сонгуулийн хороо 1,864.0 мянган төгрөгийг арвилан хэмнэлттэй зарцуулж, СЕХ-ний дансанд буцаан төвлөрүүлсэн байна.
3. Орон нутгийн сонгуулийг зохион байгуулахтай холбогдон УБЕГ-аас 4,698.0 мянган төгрөг хуваарилан зарцуулжээ.
4. СЕХ-ний баталсан журмын дагуу аймаг, сумын Сонгуулийн хорооны зардлын төсөв, гүйцэтгэлийг тайлагнасан байна.
5. Сумдын Сонгуулийн хорооны шуудан холбооны зардлын зарцуулалтын татварын цахим баримт хувь хүн дээр бүртгэгдсэн байна.

ЗӨВЛӨМЖ

**Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн Аймгийн сонгуулийн хорооны дарга
Ч.Жавзанпагма, нягтлан бодогч Э.Бүжинлхам нарт зөвлөх нь:**

1. Сонгуулийн хорооны зардлын анхан шатны баримтын бүрдүүлэлтэд анхаарч ажиллах
2. Баянжаргалын сумын хувь хүнээс суутгаагүй ХХОАТ-ыг суутгаж төсөвт тушаах, зарцуулагдаагүй шатахууныг орлогод авахуулах

Тайлан хянасан:

Дарга, Тэргүүлэх аудитор:	Ц.Хишигжаргал
Аудитын менежер:	О.Амаржаргал
Тайлан бичсэн: Аудитор	Ж.Бямбацогт
	Б.Нямсүрэн

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ

